**УЛААНБААТАР ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ**

**ТУРШИЛТЫН ТӨСЛИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ**

**ДЭЛХИЙН БАНКНЫ САНАЛ ЗӨВЛӨМЖ БҮХИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**Хүснэгт 1 – Бууруулах арга хэмжээ**

| Асуудал | Бууруулах арга хэмжээ | Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд) | Хариуцагч этгээд |
|---|---|---|---|
| **Барилгын ажлын явцад (2014 оны 10 дугаар сар хүртэл)** | | | |
| Хортон шавьж, мэрэгч устгах бодис ашиглалт | Хортон шавьж, мэрэгч устгах бодис ашиглахыг хатуу хориглоно. Энэ талаар тендерийн баримт бичиг тодорхой заасан. | Нэмэлт зардал шаардлагагүй. | Гэрээт гүйцэтгэгч |
| Иргэд, олон нийтийн хандлага | Олон нийтийн судалгаа (судалгааны дүнг гаргасан). Гэрээт гүйцэтгэгч нь барилгын ажил эхлүүлэхээсээ өмнө төлөвлөлтийн бүсийн харъяалагдах дүүрэг, багийн удирдлагатай уулзах хэрэгтэйгээс гадна ойр орчимын буддын сүм, хийдийнхэнд ажлын явцад гүйцэтгэх томоохон ажлын талаар урьдчилан мэдэгдэх шаардлагатай. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |
| Химийн бордоо ашиглалт | Химийн бордоонд амьд биетийг нэмж оруулах хэрэгтэй. Зарчмын хувьд химийн бордоо хэрэглэх нь санал болгож буй ботаникийн аргачлалтай нийцэхгүй бөгөөд хотын цэвэрлэх байгууламжийн лаг, ахуйн органик хаягдлын аль аль нь нэмэлт амьд биет бүхий бордоонд агуулагдах ёсгүй. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |
| Дуу чимээний бохирдол | Төлөвлөлтийг эс тооцон барилгын ажлыг нь өдрийн цагаар 07:00 –23:00 хооронд хийнэ. Ихэнх тохиолдолд Улаанбаатар хотноо хэрэгжүүлж буй цэцэрлэгжүүлэлийн ажлын явцад дуу чимээ, чичиргээ үүсэх нь харьцангүй бага. Хөрс хуулах гүн төдийлөн их бишээс гадна гэрэлтүүлгийн шон, явган зам, ус хадгалах сав, агуулахын зориулалт бүхий бага оврын байгууламж барьж байгуулах ажилд хүчин чадал ихтэй тоног төхөөрөмж, машин механизм хэрэглэхгүй бөгөөд ашиглах машин, механизмийн хөдөлгүүрээс үүсэх дуу чимээ, чичирхийлэл ойр орчимд тархах нь бага, богино хугацаатай байна.Одоогоор Монгол улсын хэмжээнд тээврийн хэрэгслийн дуу чимээ, чичирхийллийн стандарт байхгүй учир “Дуу чимээний хяналт, бохирдолын | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |

| Асуудал | Бууруулах арга хэмжээ | Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд) | Хариуцагч этгээд |
|---|---|---|---|
| | стандарт MNS 4585:2007, Агаарын чанарын стандартыг дагаж мөрдөнө. (Дуу чимээний хэмжээ өдрийн цагаар 60dbA-аас хэтрэхгүй (07:00 – 23:00 [A хэмжигдхүүн]). Монгол улсад барилгын ажилд ашиглах машин, механизмийн хөдөлгүүрийн дуу чимээг багасгагч, хянагч суурьлуулах шаардлага тавигддаггүй ч барилгын ажилд ашиглах зөвшөөрөл (ямар нэгэн дуу чимээ, чичирхийллийн талаар заасан заалт үгүй) шаардлагатай. Энэхүү зөвшөөрөлд гэрээт гүйцэтгэгчийн ашиглах машины улсын дугаар, тээврийн хэрэгсэл түүний хөдөлгүүрийн төрөл, маркийг тэмдэглэнэ.<br>Байгаль орчины хяналтын төлөвлөгөөгөөр төслийн барилгы байгууламжйин ажилд ашиглах тээврийн хэрэгслийг чимээ намсгагч, хорт хийн хаягдлыг хянагчаар тоноглохыг шаардахгүй. Төслийн талбайд ажиллах ачааны машинаас үүсэх дуу чимээг багасгах, мөн зорчих хөдөлгөөний чиглэл зэргийг Нийслэлийн холбогдох байгууллага, замын цагдаагийн газартай хамтран тодорхойлж зохион байгуулна. Хөрс хуулах зэрэг газар шорооны ажил хийгээгүй тохиолдолд талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж байршуулна. | | |
| Орчны тоосжилт | Хөрс хуулах болон бусад газар шорооны ажлын явцад хөрс, шороог услаж тоос дэгдэлтийг бууруулна. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |
| Барилгын, ногоон болон бусад хог хаягдал | Барилгын болон ногоон хог хаягдлыг Нарангийн энгэрийн хогийн цэгрүү зөөж хаяна. Хог хаягдлыг зайлуулах ажилд Гэрээт гүйцэтгэгч аливаа төлбөр төлөх шаардлагагүй. Хог хаягдал зайлуулж тээвэрлэж буй ачааны машин нь хэдий хэмжээний хог хаягдал тээвэрлэн зайлуулсан болох талаар мэдээлэл бүхий хуудас бөглөнө. Нарангийн энгэрт хог хаяхад ямар нэг зөвшөөрөл хэрэггүй. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |
| Бусад бохирдол | Төслийн талбайд ашиглах тээврийн хэрэгслүүд нь тос болон бусад шингэн ялгаруулах тохиолдолд талбайд ашиглахыг хориглоно. Мөн төслийн талбайд машин, механизмийг засаж засварлахыг хатуу хориглоно. Тээврийн хэрэгслүүд, ургамал, тоног төхөөрөмжийг таслийн талбайд бус Гэрээт гүйцэтгэгчийн өөрийн эзэмшлийн авто зогсоол, агуулах байрлах газарт угааж цэвэрлэнэ.<br>Талбай дээр шатахуун хадгалж болохгүй. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |

| Асуудал | Бууруулах арга хэмжээ | Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд) | Хариуцагч этгээд |
|---|---|---|---|
| Шашин, шүтлэгийн шинж чанартай байгууламж, зүйлсийг хамгаалах | Хөрс хуулах болон бусад газар шорооны ажил нь Тасганы овоон дээрх Овоонд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй. Овоог нураахаас сэргийлэх үүднээг Овооноос 2 метрийн дотор 1 метрээс илүү гүнзгий нүх ухахгүй. Түүнчлэн хөрш зэргэлдээх шашн, шүтлэгийн шин чанартай байгууламжид халдаж гэмтээхүйц ажил хийгдэхгүй.<br>Овоо орчимд хамгийн дээд тал нь 1 метрийн өндөртэй байгууламж байх бөгөөд ингэснээр цаашид гарц болзошгүй эвдрэлээс сэргийлэх юм.<br>Мөн төлөвлөлтийн 1 дүгээр бүсэд Гэрээт гүйцэтгэгчийн ажилчидад Овооны хүндэтгэлийн утга, учрыг таниулан тайлбарлаж ажлын явцад ямар нэгэн байдлаар эвдэх, сүйтгэхээс сэргийлнэ. Нийслэлийн Соёлын газрын ажилтан, мэргэжилтнүүд барилгын ажил эхлэхээс өмнө тус талбайд ажиллах нийт ажилчидад Тасганы овооны талаарх түүхэн мэдээлэл танилцуулна.<br>Барилгын ажлын явцад байдлаар Овоог нүүлгэх, нураах зэрэг хөндөхгүй бөгөөд хэрэв ямар нэгэн байдлаар будгийн ажил хийх тохиолдолд Овоог гялгар уут болон бусад хамгаалалтын бүрхүүлээр хулдаж будаг хүрхээс хамгаална.<br>Талбайд ажиллах хэн ч болов Овооны чулууг авах, буулгахыг хатуу хориглох бөгөөд барилгын ажлын явцыг фото зургаар баримтжуулж Овооны хэлбэр хэмжээ өөрчлөгдсөн эсэхийг хянана. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүцэтгэгч болон Завлах баг нь талбайд ажиллагсад, барилгын ажилд оролцох гүйэтгэгчийн удирдлагыг зохих мэдээллээр хангах үүрэгтэй. |
| Шашин, шүтлэгийн билэгдэл бүсрүү орох, гарах | Аюулгүй ажиллагааны дүрмээр барилгын ажлын явцад Төлөвлөлтийн бүсэд зочид нэвтрэх тохиолдолд тодорхой зааварчилгаар дагана. Барилгын ажлын явцад төлөвлөлтийн бүсэд зочид нэвтрэх боломж бүрдүүлэх үүднээс түр явган зам байгуулна. Талбайд төлөвлөсөн ажил хийгдэж дуусsанаар байнгын явган зам хийгдэж Тасганы овоо орчимд зочид зорчих аюулгүй орчин бий болно. Талбай дээр машин, механизм ажиллаж байх тохиолдолд хамгийн багадаа 2 метрээс хол зайд түр явган зам байх бөгөөд зочид талбайд нэьщвтрэх тохиолдол бүрт талбайд ажиллаж буй хэн нэгэн ажилтан зочныг аюулгүй чиглэлд газарчилна. Барилгын ажлын явцад төлөвлөлтийн бүс орчимд хамгийн ойр байрлах ТүвлэнПэлжээлийн хийдэд ямар нэгэн томоохон хэмжээний арга хэмжээ зохиогдохгүй болохыг тодруулж баталгаажуулсан болно. | Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй. | Гэрээт гүйцэтгэгч |
| Гэнэтийн олдвор | Археологи, палентолги, соёлын эд өлгийн зүйл талбайгаас олдох тохиолдолд нэн даруй ажлыг зогсоож олдворын хэсгийг хашиж хамгаалж “Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар”-т мэдэгдэнэ. Мөн дээрх тохиолдолд | Ямарваа нэгэн эд өлгийн олдвороос үүдэн барилгын | Гэрээт гүйцэтгэгч / Нийслэлийн байгаль орчин, |

<table>
<tr><th>Асуудал</th><th>Бууруулах арга хэмжээ</th><th>Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд)</th><th>Хариуцагч этгээд</th></tr>
<tr><td></td><td>дараахь арга хэмжээг авна. Үүнд:<br>- “Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар” олдворын зүйлээс хамаарч Шинжлэх ухааны академи, Палентологийн лаборатори, Музей, Архелогийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн зэрэг байгууллагуудад мэдэгдэж талбайн болон тухайн олдворыг шинжлүүлж үнэлүүлнэ.<br>- Олдвор олдсон газар орчимын фото зургийг авах зэргээр олдворын акт үйлдэнэ.<br>- Зөвхөн “Шинжлэх ухааны академ”-ийн шинжээч эдэмтэдийн зааварчилгаа, удирдамжийн дагуу тухайн олдворыг ухаж гаргах, шилжүүлэх ажлыг хийнэ. Бага хэмжээний архелогийн олдвор зүйлийг албан зөвшөөрлийн дагуу Гэрээт гүйцэтгэгч шилжүүлж болно.<br>Соёл, түүхэн эд өлгийн шинжтэй зүйлийг дур мэдэн талбайгаас холдуулж, зайлуулсан тохиолдолд тухайн этгээд Монгол улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.</td><td>ажлыг зогсоох тохиолдолд НЗДТГ гэрээт гүйцэтгэгчид нөхөн олговор олгоно.</td><td>ногоон хөгжлийн газар</td></tr>
<tr><td>Ажлын байран дээрх аюулгүй байдал</td><td>Ажлын байран дээр шаардагдах аюулгүй ажиллагааны тоног хэрэгслийг техникийн даалгаварт заасан бөгөөд дор хүснэгтээр оруулав.<br>Хүснэгт: Талбайд ашиглах аюулгүй ажиллагааны тоног хэрэгсэл
<table>
<tr><th>Шаардагдах*<br>Байвал зохих*</th><th>Хамаарах ажилчид</th><th>Зориулалт</th></tr>
<tr><td>Хамгаалалтын малгай*</td><td>Ажилчид</td><td>Ердийн барилгын ажлын явцад хэрэглэнэ.</td></tr>
<tr><td>Хамгаалалтын бээлий**</td><td>Ажилчид</td><td>Ажлын явцад шарх, гэмтэл авах, бордоонд түлэгдэхээс хамгаална.</td></tr>
<tr><td>Амны хаалт + нүдний хамгаалалтын шил*</td><td>Ажилчид</td><td>Хортон шавж устгах хор хэрэглэх үед шаардлагатай тохиолдолд хэрэглэнэ.</td></tr>
</table></td><td>Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй.</td><td>Гэрээт гүйцэтгэгч</td></tr>
</table>

<table>
<tr><th>Асуудал</th><th>Бууруулах арга хэмжээ</th><th>Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд)</th><th>Хариуцагч этгээд</th></tr>
<tr><td></td><td><table>
<tr><td>Хамгаалалтын гутал**</td><td>Ажилчид</td><td></td></tr>
<tr><td>Гэрэл ойлгогч бүхий богино ханцуйтай хүрэм<br>(ялгах/замын хөдөлгөөн)**</td><td>Хувьсгалчдын өргөн чөлөө дагуух бүх ажилчид хэрэглэнэ.</td><td>Төлөвлөлтийн бүсд ажиллаж буй бүх ажилчид тээврийн хэрэгслийн жолоочид ялгаж харагдахуйц байх.</td></tr>
<tr><td>Бусад: татрангын эсрэг тарилга*</td><td>Нийт ажилтан, ажиллагсад</td><td>Бүх төрлийн гэмтэл</td></tr>
<tr><td>Бусад: анхны тусламжийн хайрцаг *</td><td>Бүгд</td><td>Бүх төрлийн гэмтэл</td></tr>
</table></td><td></td><td></td></tr>
<tr><td>Зочдын аюулгүй байдал (төлөвлөлтийн бүс 1)</td><td>Барилгын ажил хийгдэж буй талаарх тэмдэг, таниулах самбар. Шонгын нүхний гүн 50 см-ээс ихгүй байна.</td><td>Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй.</td><td>Гэрээт гүйцэтгэгч</td></tr>
<tr><td>Явган зорчигчдын аюулгүй байдал (төлөвлөлтийн бүс 2)</td><td>Замаар зорчих явган зорчигчдод үзэгдэхүйц байрлалд барилгын ажил хийгдэж буй талаар тэмдэг, таниулах самбар байрлуулна.</td><td>Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй.</td><td>Гэрээт гүйцэтгэгч</td></tr>
<tr><td colspan="4">Ашиглалтын явцад (2015 оны 9 дүгээр сар хүртэл)</td></tr>
<tr><td>Хортон шавьж, мэрэгч устгах бодис ашиглалт</td><td>Хортон шавьж, мэрэгч устгах бодис ашиглахыг хатуу хориглоно. Энэ талаар тендерийн баримт бичиг тодорхой заасан.</td><td>Зардал шаардахгүй.</td><td>Ашиглалт үйлчилгээний компани.</td></tr>
<tr><td>Химийн бордоо ашиглалт</td><td>Химийн бордоонд амьд биетийг нэмж оруулах хэрэгтэй. Зарчмын хувьд химийн бордоо хэрэглэх нь санал болгож буй ботаникийн аргачлалтай нийцэхгүй бөгөөд хотын цэвэрлэх байгууламжийн лаг, ахуйн органик хаягдлын аль аль нь нэмэлт амьд баиет бүхий бордоонд агуулагдах ёсгүй.</td><td>Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй.</td><td>Ашиглалт үйлчилгээний компани.</td></tr>
<tr><td>Ердийн болон ногоон хог хаягдал</td><td>Зочид ашиглах зориулалтаар хогийн сав байрлуулна. Ногоон хог хаягдлыг “Ашиглалт үйлчилгээний компани” цуглуулна. Ямар ч төрлийн ахтуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгрүү тээвэрлэх эсхүл талбайн гадна дахин ашиглах зориулалтаар боловсруулж болно..</td><td>Хог хаягдал зайлуулах зардалыг тендерт оролцогсод тооцон</td><td>Ашиглалт үйлчилгээний компани.</td></tr>
</table>

<table>
<tr><th>Асуудал</th><th>Бууруулах арга хэмжээ</th><th>Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд)</th><th>Хариуцагч этгээд</th></tr>
<tr><td></td><td></td><td>ажлын/санхүүгийн саналдаа тусгана.</td><td></td></tr>
<tr><td>Шашин шүтлэгийн шинж чанартай байгууламж, эдийг хамгаалах</td><td>Тасганы овоо цэцэрлэгт хүрээлэнг хариуцан ажиллуулах ашиглалт, үйлчилгээний компанийн ажилтнуудад тус Овооны түүхэн ач холбогдол, шашны билэгдэл болох талаар таниулан мэдээлэл олгох. Нийслэлийн соёлын газар болон Зөвлөх баг хамтран ашиглалт, үйлчилгээ эхлэхээс өмнө буюу 2015 оны 4 дүгээр сарын үед мэдээлэл түгээх нэг цагийн танилцуулга зохион байгуулах хэрэгтэй. Цаг агаарын нөхцөл байдлаас хамааран танилцуулгын товыг нарийвчлана.</td><td>Нэмэлт зардал шаарлагатай гэж үзэхгүй.</td><td>Ашиглалт үйлчилгээний компаниуд, Зөвлөх баг хамтран ашиглалт, үйлчилгээний ажилд оролцогч бүх этгээдэд мэдээлэл түгээнэ.</td></tr>
<tr><td>Аюулгүй ажиллагаа</td><td>Аюулгүй ажиллагааны тоног, хэрэгслүүд:
<table>
<tr><th>Шаардагдах*<br>Байвал зохих*</th><th>Хамаарах ажилчид</th><th>Зориулалт</th></tr>
<tr><td>Хамгаалалтын бээлий**</td><td>Ажилчид</td><td>Ажлын явцад шарх, гэмтэл авах, бордоонд түлэгдэхээс хамгаална.</td></tr>
<tr><td>Гэрэл ойлгогч бүхий богино ханцуйтай хүрэм<br>(ялгах/замын хөдөлгөөн)**</td><td>Хувьсгалчдын өргөн чөлөө дагуух бүх ажилчид хэрэглэнэ.</td><td>Төлөвлөлтийн бусд ажиллаж буй бүх ажилчид тээврийн хэрэгслийн жолоочид ялгаж харагдахуйц байх.</td></tr>
<tr><td>Бусад: татрангын эсрэг тарилга*</td><td>Нийт ажилтан, ажиллагсад</td><td>Бүх төрлийн гэмтэл</td></tr>
<tr><td>Бусад: анхны тусламжийн хайрцаг *</td><td>Бүгд</td><td>Бүх төрлийн гэмтэл</td></tr>
</table></td><td>Эдгээр тоног хэрэгслийн талаар Ашиглалт үйлчилгээний компанийн ажлын даалгавар тусгэх учир нэмэлт зардал шаардагдахгүй.</td><td>Ашиглалт үйлчилгээний компани</td></tr>
</table>

| Асуудал | Бууруулах арга хэмжээ | Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд) | Хариуцагч этгээд |
|---|---|---|---|
| **Бүрэлдэхүүн хэсэг B Дулаан хуримтлуур бүхий цахилгаан халаагуур суурилуулах** | | | |
| Дуу чимээний бохирдол | Төхөөрөмжийг суурилуулах болон цахилгааны кабель угсрах үед бага зэрэг дуу чимээ гарах авч стандартаас давахгүй. | | |
| Тоос шороо | Цахилгааны кабель татах үед бага зэргийн тоос шороо үүсэх магадлалтай хэдий ч хорт нөлөөлөл үзүүлэх хэмжээнд хүрэхгүй. | Шаардагдахгүй | Гэрээт гүйцэтгэгч |
| Энгийн хог хаягдал | Цахилгааны кабель татах болон төхөөрөмжийг угсрах үед үүссэн хог хаягдлыг хог хаях цэгт зөөж хаяна. | Шаардагдахгүй | Хэрэглэгч |
| Аюулгүй ажиллагаа (Хамрах хүрээ: цахилгаан түгээх дэд төвөөс төхөөрөмжийг суурилуулах айл өрх хүртэлх цахилгааны кабель угсралтын ажил) | Цахилгааны кабель угсралтын болон цахилгаан, хүчдэлтэй холбоотой аливаа ажлыг зөвхөн мэргэшсэн, тусгай зөвшөөрөлтэй техникийн мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Үүнд тухайн төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг нь хариуцах болон цахилгааны болон хүчдлийн кабель утасны гэмтлийг засварлах зэрэг үйл ажиллагааг бүгдийг нь хамтад нь ойлгоно.<br><br>Аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө цахилгаан хүчдлийг салгаж хамгаалах газардуулгыг тухайн ажил гүйцэтгэх хэсэгт төдийгүй шаардлагатай тохиолдолд тухайн сүлжээнд зайлшгүй хийнэ.<br><br>Цахилгааны утас, угсралтын аливаа ажлыг техникийн мэргэшсэн ажилтнууд аюулгүй ажиллагааны болон дулаан хамгаалалтын зохих горим, стандартыг ягштал баримтлан гүйцэтгэж буйг баталгаажуулна.<br><br>Цахилгаан, хүчдэлийн кабель угсралтын ажлаас бусад буюу дэд станцууд болон сүлжээг хариуцаж буй ажилтнууд хамгаалалтын зурвас, ажлын талбар, тоног төхөөрөмжийг бэлтгэх,  машин техник хэрэгсэл ашиглах зэрэг холбогдох хууль журам, дүрэм, стандартыг мөрдөж ажиллана.<br><br>Цахилгааны шон хоорондын зайг хамгийн бага байлгана.<br><br>Ажлыг эхлүүлэхийн өмнө туршилтын байгууламжийг хийнэ.<br><br>Унаж гэмтэхээс сэргийлсэн сургалтын хөтөлбөр боловсруулж сургалтыг зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрт авирах техник, унаж гэмтэхээс сэргийлэх арга зам, тоног төхөөрөмж тэдгээрийг ашиглах, хамгаалах тухай | Шаардагдахгүй<br><br>Эдгээр арга хэмжээ болон тоног төхөөрөмжийг ашиглалт, үйлчилгээг хариуцсан гэрээт гүйцэтгэгч гаргана. | Ашиглалт үйлчилгээ хариуцах компани |

| Асуудал | Бууруулах арга хэмжээ | Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд) | Хариуцагч этгээд |
|---|---|---|---|
| | болон унаж гэмтсэн тохиолдолд авах арга хэмжээ зэрэг сэдвүүд зайлшгүй орно.<br><br>Унаж гэмтэхээс 100 хувь сэргийлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдүүлнэ. (тухайлбал, ажлын гадаргуугаас ерөнхийдээ 2 метрээс дээш байдаг хэдий ч тухайн ажилбараас шалтгаалаад 7 хүртэлх метр гэж үзэх нь бий)<br><br>Шонгуудад байрлуулах тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг суулгахдаа унаж гэмтэхээс сэргийлэх бүхий л арга хэмжээг авна.<br><br>Хамгаалалтын бүс хэрэглэх ба энэхүү бүс нь 16мм-ээс багагүй нейлон эсвэл ижил төстэй материалаар хийсэн байна. Аюулгүй ажиллагааны олсон бүсийг элэгдэж, муудсан шинж тэмдэг илэрсэн тохиодолд огт хэрэглэхгүй.<br><br>Ажил гүйцэтгэхэд саад болох тэмдэг тэмдэглэгээг шонгоос болон цахилгаан угсрах байгууламжаас зайлуулна.<br><br>Тухайн байгууламжид ажиллахдаа ашиглах багаж тоног төхөөрөмжүүдэд зохих тэмдэг тэмдэглэгээ, хаягжуулалтыг батлагдсаны дагуу хийнэ.<br><br>- | | |
| Санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт | Санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмын дагуу нэмэлт санхүүжилтын хүрээнд хийгдэх үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ. Ийн иргэд, олон нийт, харилцагч талуудаас санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авах тогтсон механизм нь хариуцлагатай байдлаа дээшлүүлэх, төслийн үйл ажиллагааны талаарх оролцогч талуудын дуу хоолой, санал хүсэлтийг сонсох боломж бүрдүүлэх зорилготой.<br><br>Санал хүсэлт, өргөдөл гомдлыг бичгээр, утсаар, цахимаар болон биечлэн ирэх гэсэн 4 аргаар хүлээн авч бүртгэн нягтлан шалгана. Нягтлан шалгасны дараагаар шийдвэрлэж хариуг утсаар эсвэл бичгээр, зарим тохиолдолд биечлэн эзэнд нь мэдэгдэнэ.<br><br>Нэгжийн томилогдсон ажилтан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хариуцан ажилладаг. Нэгжээс өгсөн хариу шийдвэрт сэтгэл хангалуун бус аваас энэ тухайгаа хотын захиргааны өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэх төвд | Шаардагдахгүй | ТУН |

| Асуудал | Бууруулах арга хэмжээ | Бууруулах арга хэмжээний зардал (шаардлагатай гэж үзэх тохиолдолд) | Хариуцагч этгээд |
|---|---|---|---|
| | хандана. Ядуу, ӨТЭ, өндөр настан зэргийг шаардлагатай тохиолдолд харгалзаж үзэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг нь яаралтай, түргэн шийднэ. | | |

**Хүснэгт 2-А – Нийгмийн хамгааллын нөлөөлөл**

| Нөлөөлөл | Тайлбар | Нөлөөллийн зэрэг |
|---|---|---|
| Хүйс | Эмэгтэйчүүдийн гэр бүлдээ голлон гүйцэтгэж буй үүрэг хариуцлага буюу хоол унд хийхдээ гал түлж, нүүрс түлээтэй өдөр тутамдаа харьцаж байдгаас үүдэн тэд бохирдолтой агаараар илүү амьсгалдаг. Түүнчлэн өрхийнхөө төсвийг эмэгтэйчүүд голдуу эрхлэн удирддаг тул тэдний оролцоо тухайлбал, өргөдөл гомдол, санал хүсэлтийг гаргах, хороо, дүүргийнхэнтэй харилцах зэргээр их байсныг энэхүү бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа тэнцвэртэй болгоно.<br><br>Нэмэлт санхүүжилтээр хийгдэх энэхүү ажил нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангана. Дулааны хуримтлуур бүхий цахилгаан халаагуур буюу цэвэр технологийг нэвтрүүлж өрхөд суурилуулснаар үүрэгт ажлын тэнцвэргүй байдал багасч бохирдолтой агаараар байнга амьсгалахгүй болно. Түүнчлэн нүүрс зөөх, түлэх багасна. Өрх толгойлсон эмэгтэйчүүд орлого багатай байдаг бол цахилгаан халаагуур суурилуулснаар гэр орноо халаахад зарцуулж буй цаг багасах бөгөөд хэмнэсэн цагийг өөр бусад орлого олох боломж бүхий ажил, зүйлсэд зарцуулах боломжтой бий болж улмаар орлогоо нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх юм. | Дунд зэрэг |

**Хүснэгт 2 – Байгаль орчны хяналтын төлөвлөгөө**

| Юуг | Хаана | Хэрхэн | Хэзээ | хяналтын зардал | Хариуцлага |
|---|---|---|---|---|---|
| *Хяналтын хамрах хүрээ нь юу байх вэ?* | *Хяналт хийх параметр нь хаана байх вэ?* | *Параметрт хяналт хэрхэн хийх вэ / хяналтын тоног төхөөрөмжийн төрлүүд?* | *Параметрт хэзээ хяналт хийх вэ – хэмжилтийн давтамж?* | *Хяналтхгд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал буюу гэрээлэгчид төлөх хөлс* | *Хяналтыг хэн хариуцах вэ?* |
| **Барилгын ажлын явцад (2014 оны 10 дугаар сар хүртэл)** | | | | | |
| Оршин суугч, хэрэглэгчдийн хүлээн авч буй байдал | **Төлөвлөлтийн бүс 1** 1.7га **Төлөвлөлтийн бүс 2** 305м x 2.5м улаан шугамын бүс | Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар, НЗДТГ-т ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын тоо. Ажлын хэсгийн уулзалт | Барилгын үе шатын туршид сар бүр | Нэмэлт зардал байхгүй. | Хариуцагч: Гэрээт гүйцэтгэгч<br>Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Зөвлөх багийн туслалцаатай |
| Химийн бордоо ашиглалт | | Газар дээрх ажиглалт + чанар-Гэрээт гүйцэтгэгчийн ашиглаж буй бордоог шалгах. Зарчмын хувьд санал болгож буй ботаникийн төрөл зүйлд химийн бордоо ашиглах нь зохимжгүй юм. | Хяналт хийж буй Зөвлөх баг барилгын үе шатын туршид төлөвлөлтийн бүсэд тогтмол очиж ажиллах | Нэмэлт зардал байхгүй. | Хариуцагч: Гэрээт гүйцэтгэгч<br>Хяналт: БОНХГ-ын хяналтын дор Зөвлөх баг |
| Дуу чимээ, орчны тоосжилтын түвшин | | Оршин суугчдын зүгээс Чингэлтэй дүүрэгт ирүүлсэн санал, гомдол (1) + барилгын ажлын үед төлөвлөлтийн бүсэд очих, оршин суугчидтай ярилцах (2) | Чингэлтэй дүүргээс БОНХГ-т ирүүлдэг сар тутмын тайлан (1).<br>Хяналт хийж буй Зөвлөх баг төлөвлөлтийн бүсэд ойролцоогоор 8 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэнэтийн байдлаар очиж ажилтай нь танилцаж, шалгах (2) | Заавал бус: Агаарын чанарын албаны агаарын чанарыг шалгах тоног төхөөрөмжөөр төлөвлөлтийн бүс дэх тоосжилтыг хэмжих (3 сар) – Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар шийдвэрлэнэ. Зардлыг НЗДТГ-аас гаргана. | Хариуцагч: Гэрээт гүйцэтгэгч<br><br>Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хяналтын дор Зөвлөх баг (заавал)<br><br>Агаарын чанарын заавал бус гүйцэтгэх Хяналт: НЗДТГ-ын Агаарын чанарын алба гүйцэтгэнэ. |

| Юуг | Хаана | Хэрхэн | Хэзээ | хяналтын зардал | Хариуцлага |
|---|---|---|---|---|---|
| Ногоон болон ердийн хатуу хаягдал (иргэд) | | Төлөвлөлтийн бүсэд очиж ажиллахдаа НЗДТГ болон Зөвлөх баг зогсоолд байрлуулсан болон ажиллаж буй тээврийн хэрэгсэл, хөдөлгүүрт төхөөрөмжийн гэрчилгээг шалгана.<br><br>Ногоон хог хаягдлыг ногоон байгууламжийн туршлагын дагуу дахин боловсруулах (холимог бордоо, хучлага). Ашиглалт, үйлчилгээ хариуцсан компани хог хаягдлын савыг тогтмол суллаж буй эсэхийг шалгах.<br>Гэрээт гүйцэтгэгчээс бүх хог хаягдлыг Нарангийн энгэрийн хогийн цэгрүү зөөвөрлөж ачсан тухай нотолгоог гаргуулах (тамга дарж, гарын үсэг зурж, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар т хүргүүлэх баримт бичиг), тус нотолгоонд хог ачигч ажилтнаас авсан төлбөрийн баримтын эх хувь буюу хуулбарыг хавсаргах. Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар болон Зөвлөх баг нь хогийн цэгрүү ачуулсан хог хаягдлын тоо хэмжээ нь барилгын ажлын хэмжээ, шинж чанарын уялдаа хамаарлыг нягталж шалгана. Боломжтой бол хогийн машины ачигч, жолооч нартай Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хяналт удирдлагын дор уулзаж ярилцах. | Зөвлөх баг газар дээр нь очиж ажиглалт хийх, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газартай хэлэлцэх. Гэрээт гүйцэтгэгч нь хог хаягдлыг зохих ёсоор цуглуулж, зайлуулж/дахин боловсруулж буй эсэх | Нэмэлт зардал байхгүй | Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, хаягдал зөөвөрлөх хэрэгслийн гэрчилгээтэй холбоотой мэдээлэл: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар |
| Хортон шавьж, мэрэгч устгах бодис, бордоо ашиглалт | | Хортон шавьж устгах бодис ашиглахыг зөвшөөрөхгүй тул Зөвлөх баг лабораторид шалгах ургамал, хөрсний дээжийг сонгож хөнөөлт шавьж устгах бодис агуулагдсан эсэхийг шалгана. Бордоо ашигласан эсэхийг ч мөн дээрхийн ижил аргаар шалгана. | Тариалалт эхэлснээс хойш 4 долоо хоног хүртэл | Шинжилгээ хийлгэхэд 2000 ам.доллар | Зөвлөх баг хянана. НЗДТГ нь шинжилгээний зардлыг санхүүжүүлнэ. |

| Юуг | Хаана | Хэрхэн | Хэзээ | хяналтын зардал | Хариуцлага |
|---|---|---|---|---|---|
| Бусад бохирдол | | Гэрээт гүйцэтгэгчээс тээврийн хэрэгслийн нөхцөл байдал, засвар, төлөвлөлтийн бүс дэх шатамхай бодисын хадгалалтын талаар ирүүлсэн албан мэдэгдэл (барилгын ажил эхлэхийн өмнө) | Зөвлөх баг ажлын цагаар төлөвлөлтийн бүсэд очиж ажиллах | Нэмэлт зардал байхгүй | Хариуцагч: Гэрээт гүйцэтгэгч<br><br>Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хяналтын дор Зөвлөх баг Зөвлөх баг (заавал) |
| Шашны эд зүйлсийг хамгаалах | **Төлөвлөлтийн бүс 1**<br>1.7га<br><br>**Төлөвлөлтийн бүс 2**<br>305м х 2.5м улаан шугамын бүс | Овооны тогтвортой байдлыг хангах үүднээс 2м-ийн дотор томоохон хэмжээний (1м-ээс гүн) малталт хийхгүй байх. Зэргэлдээх шашны байгууламж, эд зүйлст эвдрэл гэмтэл учруулахгүй байх. Гэрээт гүйцэтгэгч нь Овоо, Тасганы овооны шашны утга учир, үнэ цэнийн талаар өөрийн ажилтнуудлаа ойлгуулж, таниулах зорилгоор хурал зохион байгуулах.<br>Зөвлөх баг Төлөвлөлтийн бүс 1-д очиж ажиллах үеэрээ Овооны зургийг авна (хойд, баруун, өмнөд, зүүн өнцгөөс 4 зураг авах). Овооны суурийн диаметрийг хэмжиж тэмдэглэсэн үү? Зөвлөх баг овоонд ажиглалт хийснээр барилгын холбогдолтой зүйлс (төмрийн тайрдас, хөрс, будаг) овоог бохирдуулахаас сэргийлэх боломжтой. НЗДТГ нь Овоог барилгын ажилд өртөхөөс сэргийлэх энэхүү ажиглалтын 2-т нь хамрагдах ажилтныг томилох шаардлагатай.<br>Зөвлөх баг нь төлөвлөлтийн бүсэд очиж ажиллах үеэрээ гэрээт гүйцэтгэгчийн ажилтнуудтай уулзалт, ярилцлага хийнэ.<br>Дүүргүүд, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар, НЗДТГ-т иргэд, шашны байгууллагуудын удирдлагаас (шууд: утсаар, биеэр ирж, захидлаар, вэбсайтаар) зэргэлдээх шашны байгууламжид эвдрэл гэмтэл учирч болзошгүй талаар ирүүлсэн санал | Барилгын үе шатын турш Зөвлөх баг 8 удаагийн төлөвлөгөөт буюу урьдаас мэдэгдэлгүй төлөвлөлтийн бүсэд очиж ажиглалт хийнэ (12 долоо хоног гэж тооцоолж байгаа бөгөөд дунджаар 10 өдөрт 1 байна) + иргэд, шашны байгууллагуудын удирдлагаас ирүүлсэн санал гомдлын мөрөөр | Нэмэлт зардал байхгүй | |

| Юуг | Хаана | Хэрхэн | Хэзээ | хяналтын зардал | Хариуцлага |
|---|---|---|---|---|---|
| | | гомдлын мөрөөр эдгээр эвдрэл гэмтлийг гэрээт гүйцэтгэгч учруулсан эсэхийг тодруулах. | | | |
| Шашны байгууламж, талбайд нэвтрэх | | Зөвлөх баг төлөвлөлтийн бүсэд очиж ажиллах Дүүргүүд, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар, НЗДТГ-т иргэд, шашны байгууллагуудын удирдлагаас (шууд: утсаар, биеэр ирж, захидлаар, вэбсайтаар) ирүүлсэн санал гомдлын мөрөөр | Барилгын ажлын явцад Зөвлөх баг 8 удаагийн төлөвлөгөөт буюу урьдаас мэдэгдэлгүй төлөвлөлтийн бүсэд очиж ажиглалт хийнэ (12 долоо хоног гэж тооцоолж байгаа бөгөөд дунджаар 10 өдөрт 1 байна) + иргэд, шашны байгууллагуудын удирдлагаас ирүүлсэн санал гомдлын мөрөөр | Нэмэлт зардал байхгүй | |
| Гэнэтийн олдвор | | Гэрээт гүйцэтгэгчээс Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газарт ирүүлсэн мэдэгдэл | Гэнэтийн олдвор олдохгүй бол хяналт хийхгүй (МШУА-ийн тохирох хүрээлэнтэй хамтран тодорхойлох) | Хэрэв гэнэтийн олдворын улмаас барилгын ажил зогссон бол НЗДТГ нь Гэрээт гүйцэтгэгчид нөхөн төлбөр төлнө. | Хариуцагч: Гэрээт гүйцэтгэгч<br>Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар болон МШУА-д хүсэлт тавин оролцуулах. СШУАЖЯ-д мэдэгдэх |
| Ажлын байран дээрх аюулгүй байдал | | Гэрээт гүйцэтгэгч, түүний ажилтнуудаас ослын талаар ирүүлсэн мэдэгдэл + ажилтнуудтай хийх ярилцлага (Зөвлөх баг) + газар дээрх ажиглалт | Осол аваар болохгүй бол хяналт хийгдэхгүй. Ийм тохиолдолд Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар долоо хоног бүр төлөвлөлтийн бүсэд очиж ажиллана. | Тендерийн баримт бичигт тусгасан шаардлагатай тоног төхөөрөмж (Гэрээт гүйцэтгэгч) | Хариуцагч: Гэрээт гүйцэтгэгч<br>Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар -ын хяналтын дор Зөвлөх баг Ажлын байран дээрх аюулгүй байдалд хяналт хийх: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар |
| Иргэд, явган зорчигчдын аюулгүй байдал (Төлөвлөлтийн бүс 2) | **Төлөвлөлтийн бүс 1**<br>1.7га<br>**Төлөвлөлтийн бүс 2**<br>305м x 2.5м | Цагдаа, эмнэлгийн тайлан. Ноцтой гэмтэл гарсан тохиолдолд барилгын ажлыг зогсоох ба НЗДТГ-ын зүгээс аюулгүй ажиллагааны арга хэмжээг авсны дараагаар ажлыг үргэлжлүүлэх | Барилгын үе шатын турш Зөвлөх баг 8 удаагийн төлөвлөгөөт буюу урьдаас мэдэгдэлгүй төлөвлөлтийн бүсэд очиж ажиглалт хийнэ (12 долоо | Тендерийн баримт бичигт тусгасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ (гэрээт гүйцэтгэгч) | |

| Юуг | Хаана | Хэрхэн | Хэзээ | хяналтын зардал | Хариуцлага |
|---|---|---|---|---|---|
| | улаан шугамын бүс | | хоног гэж тооцоолж байгаа бөгөөд дунджаар 10 өдөрт 1 байна) | | |
| **Ашиглалтын явцад (2015 оны 9 дүгээр сар хүртэл)** | | | | | |
| Химийн бордоо ашиглахаас сэргийлэх, хөнөөлт шавьж устгах бодис ашигласан эсэхийг шалгах | **Төлөвлөлтийн бүс 1** 1.7га **Төлөвлөлтийн бүс 2** 305м x 2.5м улаан шугамын бүс | Байгалийн бордоо ашиглалтыг нэмэгдүүлэх талаар Зөвлөх баг ашиглалт, үйлчилгээ харицсан компанид зөвлөх. Зөвлөх баг бордооны чанарыг шалгана. Хөнөөлт шавьж устгах бодис ашиглахыг хориглосон тул Зөвлөх баг ургамал, хөрснөөс дээж авч хөнөөлт шавьж устгах бодис байгаа эсэхийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж, шалгана. Бордоо ашигласан эсэхийг ч мөн дээрхийн ижил аргаар шалгана. | Ашиглалт, үйлчилгээ хариуцсан компани, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газартай хийх тогтмол хурал. Зөвлөх баг 2015 оны 4 дүгээр сараас 9 дүгээр сар хүртэл 6 удаа төлөвлөлтийн бүсэд очиж ажиглалт хийнэ. Шинжилгээ: ашиглалт үйлчилгээний явцад 1 удаа. | Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгасан төсөвт багтсан Үүнээс гадна: Шинжилгээ хийлгэхэд 2000 ам.доллар | Хариуцагч: ашиглалт үйлчилгээний компани Хяналт, сургалт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хяналтын дор Зөвлөх баг Шинжилгээний зардлыг НЗДТГ санхүүжүүлнэ. |
| Ердийн, ногоон хаягдал | | Зөвлөх баг талавлалтийн бүсэд очиж ажиллана. Тухайн талбай бохир байгаа талаар иргэдээс ирүүлсэн санал, гомдол. | Тооцоолол: Зөвлөх баг 2015 оны 4 дүгээр сараас 9 дүгээр сар хүртэл 6 удаа төлөвлөлтийн бүсэд очиж ажиглалт хийнэ. Зөвлөх баг, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газартай хог хаягдлыг зохих ёсоор цуглуулж, зайлуулж/ дахин боловсруулж буй эсэхийг хэлэлцэнэ | Нэмэлт зардал байхгүй | Хариуцагч: ашиглалт үйлчилгээний компани<br><br>Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хяналтын дор Зөвлөх баг |
| Ус их хэмжээгээр ашиглахыг хязгаарлах | | Эх үүсвэр: Ашиглалт, үйлчилгээ хариуцсан компанийн усалгааны төлөвлөгөө + уян хоолойн арчилгаа, засвар. Хяналт: Улаанбаатар нэгдлээс ашиглалт, үйлчилгээ харицсан компанид олгосон усны м$^3$ + ажилтнуудтай хийх ярилцлага + газар дээрх ажиглалт | Хяналтын давтамж: Хугацааны туршид сар бүр | Байхгүй | |
| Ажлын байран | | Ашиглалт, үйлчилгээ хариуцсан компани | Осол аваар болохгүй бол | Тендерийн баримт | Хариуцагч: ашиглалт, |

| Юуг | Хаана | Хэрхэн | Хэзээ | хяналтын зардал | Хариуцлага |
| --- | --- | --- | --- | --- | --- |
| дээрх аюулгүй байдал | | болон түүний ажилтнуудаас ирүүлсэн мэдэгдэл | хяналтинг хийгдэхгүй. Ийм тохиолдолд Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар долоо хоног бүр төлөвлөлтийн бүсэд очиж ажиллана. | бичигт тусгасан шаардлагатай тоног төхөөрөмж (ашиглалт, үйлчилгээний компани) | үйлчилгээний компани Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар |
| Нийгэм хүлээн авч буй байдал | **Төлөвлөлтийн бүс 1** 1.7га<br><br>**Төлөвлөлтийн бүс 2** 305м x 2.5м улаан шугамын бүс | Түүвэрлэн авсан 100 иргэний сэтгэл ханамжийн түвшин: иргэдийн овоорүү зорчих тоо, талбайн өнгө үзэмж, ногоон байгууламжийн талаарх санал сэтгэгдэл, хүртээмжтэй байдал, гэх мэт. | 2015 оны эхээр судалгаа хийх (Шинийн нэгний нар мандах үеэр) | Судалгааны зардал 2000 ам.доллар байна гэж тооцоолсон ба үүнийг НЗДТГ-аас гаргана. | Хариуцагч: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар. Судалгааны компанийг Төслийн менежер томилж, судалгааны асуулгыг хяналт хийх Зөвлөх баг боловсруулна. |
| Ургамлын ургалт | | Ногоон байгууламжийн гүйцэтгэл Биомассын үнэлгээ Хөрсний шинжилгээ | 2015 оны 9 дүгээр сар хүртэл барилга, ашиглалт, үйлчилгээний туршид (доорх хүснэгтийг үз: Зөвлөх багийн тогтоосон Ногоон байгууламжийн гүйцэтгэл **) | Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгасан төсөвт багтсан | Хяналт: Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хяналтын дор Зөвлөх баг |
| Органик матери, азот (хөрс) | | | | | |

****Хүснэгт: Санал болгож буй ногоон байгууламжийн гүйцэтгэлийг илтгэх үзүүлэлтүүд**

| |
| --- |
| Хөрс, өнгөн хөрсний зохих чанар: органик бодис, азот, гэх мэт. Хоёр жилийн хооронд хөрсний чанарт явагдах хувьсал |
| Үрийн чанар (өвсний үрийн гарц), үрсэлгээ; Өвсний гарцын хувь хэмжээ: нэгдүгээр чанарын өвсний үрийн 90 хувийн хамгийн бага хэвь хэмжээ |
| Суулгасан нас бие гүйцсэн мод сөөгний эндэгдлийн зэрэг |

| |
|---|
| Эндэгдээгүй боловч 20 хувийн эндэгдлийн зэргийг хэвийн гэж үзнэ |
| Эрүүл чийрэг мод сөөгний тоо/жилд өвчилж буй мод сөөгний тоо (төрөл зүйл тус бүрээр шинжлэх) |
| Байгалийн бордооны чанар, тоо хэмжээ / бордоо ашиглалт |
| Нэг жилд, нэг нүхэнд ашиглах химийн бордооны тоо хэмжээ, төрөл |
| Усны хэрэглээ (тоо хэмжээ) |
| Тариалалтаас хүлээгдэж буй үр дүнд харгалзах усалгааны гүйцэтгэл |
| Усалгааны системийн гүйцэтгэл: хоолойн даралт, шүүрэлт, шүршигчийн онцлог |
| Салхи тусгаарлагчийн нөлөөг үнэлэх үүднээс навч, өвсөн дээрх тоосыг ажиглах |

**Хүснэгт 3 – Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үүрэг хариуцлага**

| Үйл ажиллагаа | Үүрэг хариуцлага |
|---|---|
| Барилгатай холбоотой мэдээлэл цуглуулах | Гэрээт гүйцэтгэгч |
| Ногоон байгууламж, байгаль орчинтой холбоотой мэдээллийг хөрвүүлэх | НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР-ын хяналт дор Зөвлөх баг |
| Овооны утга учир, үнэ цэнийн талаарх ажилтнууд, тэдний удирдлагын ойлголт, мэдлэг | НЗДТГ ба Зөвлөх баг |
| Байгаль орчны тайланг бэлтгэх<br>- Хяналтын эхлэлийн тайлан (Төслийн удирдагчийн батласан хяналтын төлөвлөгөө) 2014 оны 8 дугаар сарын сүүлээр<br>- 10 дугаар сарын дундуур 1 удаа мэдэгдэх<br>- Дунд хугацааны хяналтын тайлан: 2015 оны 3 дугаар сарын 1<br>- Ашиглалт, үйлчилгээ эхэлснээс хойш 1 сарын дараа 1 удаа мэдэгдэх<br>- Ашиглалт, үйлчилгээний явцын дунд хугацаанд 1 удаа мэдэгдэх (2015 оны 8 дугаар сарын эхээр гэж тооцоолж байгаа)<br>- 2015 оны 9 дүгээр сард Хнялатын эцсийн тайлан | НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР-ын хяналт дор Зөвлөх баг |
| Хортон шавьж, мэрэгч устгах бодис, бордоо ашиглаагүй болохыг тогтоох шинжилгээ | НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР-ын хяналт дор Зөвлөх баг байж болно (Гео-экологийн хүрээлэн), эсвэл НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР-аас томилсон лаборатори |
| Инженерийн шугам сүлжээний ажилтай холбоотой мэдээлэл, байгаль орчин, ногоон байгууламж/ботаниктай шууд бус холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх | Төслийн менежер (НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР) болон нийслэлийн холбогдох бүх газрууд |
| Ажлын байран дээрх сургалт<br>Ажлын байран дээрх сургалт нь ботаникийн болон байгаль орчны асуудлуудад голлон анхаарна. Үүний зорилтот бүлэг нь гэрээт гүйцэтгэгчийн (2014) болон ашиглалт, үйлчилгээний компанийн ажилтнууд, удирдах албан тушаалтнууд байна. Зөвлөх баг нь ажлын талбар дээрх багуудын үйл ажиллагааг ажиглахын сацуу байнгын зөвлөгөө өгөх байдлаар Ажлын байран дээрх сургалтыг явуулна. Барилгын үе шатанд 8, ашиглалт үйлчилгээний явцад 6 удаа төлөвлөгөөт байдлаар төлөвлөлтийн бүсэд газар дээр нь (тооц. 2цаг/төлөвлөлтийн бүсэд газар дээр нь ажиллах) ажиллахдаа шилдэг туршлагуудыг зөвлөмж болгох, барилгын ажлын дунд хугацаанд гэрээт гүйцэтгэгчийн удирдах ажилтнуудтай (тэдний албан өрөөнд), мөн ашиглалт, үйлчилгээний эхэн үед ашиглалт, үйлчилгээ хариуцсан компанийн удирдах ажилтнуудтай хурал зохион байгуулна. Ажлын байран дээрх сургалтын талаар мэдэгдэл хүргүүлэн тайлагнах | НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР-ын хяналт дор Зөвлөх баг (төлөвлөлтийн бүсэд очиж ажиглалт хийх үеэр)<br>Зөвлөх баг болон НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР-ын хурал |

| | |
|---|---|
| ба байгаль орчны тайланд дэлгэрэнгүй тайланг багтаана. | |
| 2014 оны 10 дугаар сараас хойшхи Төлөвлөлтийн бүс 1-ийн ашиглалт, үйлчилгээ | Тасганы цэцэрлэгт хүрээлэн НӨҮГ (байгуулагдана) |
| 2014 оны 10 дугаар сараас хойшхи Төлөвлөлтийн бүс 2-ын ашиглалт, үйлчилгээ | Нийтлэг үйлчилгээний Улаанбаатар нэгдэл |
| Гэрээт гүйцэтгэгчийг санхүүжүүлэх + Зөвлөх баг | УБХНААСТ-ийн (УБЦАТ) ТУН-ээр дамжуулан НЗДТГ |
| Шаардлагатай бол үйл ажиллагааг зогсоох | Төслийн удирдагч (НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР), НЗДТГ-ын хүсэлтээр |
| Үйл ажиллагааг өөрчлөх | Төслийн удирдагч (НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗАР) НЗДТГ-ын хүсэлтээр |

*Мэдэгдэл (англи, монгол хэл дээр)-ийг тухайн ажиглагдсан асуудлуудын дагуу хүснэгт (2-4 хуудас) хэлбэрээр бэлтгэнэ. Байгаль орчны тайланг (5-10 хуудас хураангуй + хавсралт) Зөвлөх баг англи, монгол хэл дээр бэлтгэж Төслийн удирдагчид хүргүүлнэ. Төслийн удирдагч нь тэдгээрийг хүлээн авч танилцан, саналаа оруулсны дараагаар Дэлхийн Банкинд илгээнэ. Байгаль орчны мониторингийг сайжруулах, магадгүй үйл ажиллагааг өөрчлөхдөө дэлхийн банкнаас ирүүлсэн саналыг харгалзан үзнэ.

Байгаль орчны батлагдсан тайланг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлж, нийслэлийн вэб хуудсанд хураангуйлан оруулна.

**Хүснэгт 3 – Төслийн хяналтын ажил, хариуцлага**

| Хийх ажил | Хамаарах үе шат | Хариуцагч |
|---|---|---|
| **Байгаль орчны хяналтын мэдээлэл цуглуулах** | Барилга | **Гэрээт гүйцэтгэгч:** Байгаль орчин, ботаникийн мэдээлэл хүргүүлнэ.<br>**Зөвлөх баг**: талбайд ажиллах явцдаа бусад шаардагдах мэдээллийг цуглуулна. |
| | Ашиглалт | **Гэрээт гүйцэтгэгч:** Байгаль орчин, ботаникийн мэдээлэл хүргүүлнэ.<br>**Зөвлөх баг**: талбайд ажиллах явцдаа бусад шаардагдах мэдээллийг цуглуулна. |
| **Мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх** | Барилга | **Зөвлөх баг,** Төслийн удирдагчийн удирдамжийн дагуу**.** |
| | Ашиглалт | **Зөвлөх баг,** Төслийн удирдагчийн удирдамжийн дагуу**.** |
| **Байгаль орчны тайлэн бэлтгэн, боловсруулах*** | Барилга | **Зөвлөх баг,** Төслийн удирдагчийн удирдамжийн дагуу**.** |
| | Ашиглалт | **Зөвлөх баг,** Төслийн удирдагчийн удирдамжийн дагуу**.** |
| **Ажлын зохион байгуулалт** | Барилга | **Зөвлөх баг**-ийн зөвлөмжийн дагуу **Төслийн удирдагч** Гэрээт гүйцэтгэгчид хандан шаардагдах ажлын аргачлалыг өөрчлөх тухай хүсэлт гаргах.<br>**Төслийн удирдагч** Гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй гэж үзэх тохиолдолд Гэрээ цуцлах тухай мэдэгдэл хүргүүлэх. |
| | Ашиглалт | **Зөвлөх баг** эсхүл **Дэлхийн банкны** зөвлөмж, удирдамжийн дагуу **Төслийн удирдагч** Гэрээт гүйцэтгэгчид хандан шаардагдах ажлын аргачлалыг өөрчлөх тухай хүсэлт гаргах.<br>**Төслийн удирдагч** Гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй гэж үзэх тохиолдолд Гэрээ цуцлах тухай мэдэгдэл хүргүүлэх. |

**Хүснэгт: Байгаль орчин, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн гүйцэтгэлийг хэмжихээр санал болгож буй үзүүлэлтүүд**

**1. Хөрсний үзүүлэлтүүд**

| | | |
|---|---|---|
| Органик бодис, азот, гэх мэтийн тохирох чанар (хөрс, өнгөн хөрсний)<br>Хоёр жилийн хугацаан дахь өнгөн хөрсний чанарын өөрчлөлт | Зорилго: чанар/ургамалжуулалтын зорилго, ургамлын хослуулалт, дахин зохион байгуулалт + байгалийн/химийн бордооны хэрэглээг хязгаарлах, чийгшил, гэх мэт | Хяналтын давтамж: 2015 оны 8 дугаар сар<br>Эх сурвалж: Гүйцэтгэгч болон БОНХГ-аас ирүүлсэн хөрсний шинжилгээ + газар дээр нь очиж ажиглах |

**2. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн үзүүлэлтүүд**

| | | |
|---|---|---|
| Үрийн чанар (өвсний үрийн ургалт), үрсэлгээ<br>Өвсны ургалтын зэрэг<br>Хүлээгдэж буй 90% | Зорилго:<br>Үр, үрсэлгээний чанар: Үр, үрсэлгээ хангалттай эсэхийг шалгах, шаардлагатай бол нэмэлт үр, үрсэлгээний тоо гаргах<br>Ургалтын зэрэг: Бордооны ашиглалтыг оновчтой болгох, мод, бутны хосломжийг өөрчлөх, улмаар шаардлагатай байгаа нэмэлт үрийн тоо хэмжээг тодорхойлох, бүр болохгүй бол өөр төрөл зүйлийн ургамал санал болгох | Хяналтын давтамж: Үр, үрсэлгээний чанар: Үрсэлгээний өмнө хоёр удаа<br>Улаанбаатар хотод өвс ургах зэрэг: хуртай буюу чийглэг улиралын эхэн, төгсгөлд<br>(нийт 4 удаа)<br>Эх сурвалж: Шинжилгээ + Гүйцэтгэгчээс ирүүлсэн үрийн дээжид Зөвлөх багийн лабораторид хийсэн ажиглалт,<br>Нүдэн баримжаагаар тоолох + үр суулгах нэг талбайн ургалтын зэргийг тодорхойлох үүднээс фото зураг авах |
| Суулгасан нас бие гүйцсэн мод, бутны төрөл зүйлийн эндэгдлийн зэрэг<br>(Тайлбар: Эндэгдлийн зэрэг 20% байвал хэвийн гэж үзнэ) | Зорилго: бордоо/хольцтой бордоо ашиглахаас зайлсхийх/ хортон шавьж устгах хортой бодис, өнгөн хөрс ашиглахын өмнө урьдчилан сэргийлэх, ургамлын зохион байгуулалт, мод, бутны усалгааг өөрчлөх, улмаар нэмж шаардагдах мод, бутны тоо хэмжээг тодорхойлох, бүр болохгүй бол өөр төрөл зүйлийн ургамал санал болгох | Хяналтын давтамж: Хуртай буюу нойтон чийглэг улирал бүрийн эхэн болон төгсгөлд<br>(Нийт 2 удаа)<br>Эх сурвалж: Тооллого + фото зураг болон видео бичлэг (шалтгааныг нь тодруулах үүднээс) + Гүйцэтгэгчээс ирүүлсэн албан ёсны баримт бичиг + ажилтнуудтай хийх ярилцлага |
| Эрүүл, хэвийн мод, бутны тоо/жилд өвчлөлд өртөж буй мод, бутны тоо<br>(төрөл зүйл тус бүрээр | Зорилго: өвчлөлийн шалтгаан, халдвар авах эрсдэл, бордоо/хольцтой бордоо/пестицидийн ашиглалтыг тодорхойлох, ургамлын зохион байгуулалт, мод, бутны усалгааг өөрчлөх, бүр болохгүй бол | Хяналтын давтамж: Хуртай буюу нойтон чийглэг улирал бүрийн эхэн болон төгсгөлд<br>(Нийт 4 удаа)<br>Эх сурвалж: Гүйцэтгэгчээс ирүүлсэн албан ёсны баримт бичиг + газар дээрх тооллого + |

| | | |
|---|---|---|
| шинжлэх) | өөр төрөл зүйлийн ургамал санал болгох | фото зураг болон видео бичлэг (шалтгааныг нь тодруулах үүднээс) + ажилтнуудтай хийх ярилцлага |
| Хольцтой бордооны тоо ширхэг, чанар/бордоо ашиглалт | Зорилго: химийн бордоо ашиглалтыг хязгаарлах, хольцтой бордооны чанарт үнэлгээ өгөх. | Хяналтын давтамж: Хуртай буюу нойтон чийглэг 2 улирлын туршид<br>Эх сурвалж: Газар дээрх ажиглалт + Гүйцэтгэгчийн хийсэн худалдан авалтын шилжүүлгийн баримтууд + Гүйцэтгэгч компанийн ашигласан бордох аргыг ажиглах (фото зураг болон видео бичлэг) |
| Нэг жилд нэг талбайд ногдох химийн бордооны тоо хэмжээ, төрөл (хэрэв ашигласан бол) | Зорилго: Химийн бордоо ашиглалтыг хязгаарлах + ашиглалт, хадгалалтын практикийг шалгах | Хяналтын давтамж: Хуртай буюу чийглэг 2 улирлын туршид<br>Эх сурвалж: Гүйцэтгэгчийн хийсэн худалдан авалтын шилжүүлгийн баримтууд + Гүйцэтгэгч компанийн ашигласан цацлагын аргыг ажиглах (фото зураг болон видео бичлэг) |
| **3. Усалгаа** | | |
| Усны хэрэглээ (тоо хэмжээ), усны боломжит нөөцийг шалгах | Зорилго: Усалгааны тохирох хэрэглээ, ирээдүйд ашиглаж болох усалгааны өөр системийг тодорхойлох | Хяналтын давтамж:<br>Хуртай буюу чийглэг 2 улирлын туршид сар бүр<br>Эх сурвалж: Гүйцэтгэгчийн усалгааны төлөвлөгөө + Гүйцэтгэгчийн м$^3$ усанд төлсөн төлбөрийн баримт + ажилтнуудтай хийх ярилцлага + газар дээрх ажиглалт |
| Хүлээгдэж буй ургамалжуулалтын үр дүнд хамаарах усжуулалтын практик | Зорилго: усыг зохистой ашиглан усжуулалт хийх тохирох аргыг тодорхойлох, ирээдүйд ашиглаж болох усжуулалалтын өөр арга хэлбэрийг тодорхойлох | Хяналтын давтамж: Хуртай буюу чийглэг 2 улирлын туршид<br>Эх сурвалж: Гүйцэтгэгчийн усжуулалтын төлөвлөгөө + ажилтнуудтай хийх ярилцлага + газар дээрх ажиглалт (фото зураг болон видео бичлэг) |
| Усжуулалтын системийн гүйцэтгэл: уян хоолойн даралт, гоожилт, шүүрэлт, гар усалгааны онцлог | Зорилго: Усжуулалтын системийн ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх | Хуртай буюу чийглэг 2 улирлын туршид<br>Эх сурвалж: Ажилтнуудтай хийх ярилцлага + газар дээрх ажиглалт + фото зурагжуулалт |